III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	8,520,851,100.00	7,872,642,696.25	3,342,898,170.78
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	804,060,800.00	804,060,800.00	3,859,363,397.96
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	804,060,800.00	804,060,800.00	804,060,800.00
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	6,796,688,600.00	6,596,035,450.25	6,729,715,122.74
320001	Орон нутгийн төсвөөс	6,796,688,600.00	6,596,035,450.25	6,729,715,122.74
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	920,101,700.00	472,546,446.00	472,546,446.00
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	300,000,000.00	271,296,446.00	0
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	320,000,000.00	201,250,000.00	0
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	300,101,700.00	0	-62,345,089.54
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	300,101,702.01	300,101,702.01
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	713,183,439.01	713,183,439.01
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	551	514	514
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	19	18	18
610001	Төсвийн байгууллага	17	17	17
610002	Төсвөөс гадуур байгууллага	2	1	1
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	266	248	248
620001	Удирдах ажилтан	15	15	15
620002	Гүйцэтгэх ажилтан	35	35	35
620003	Үйлчлэх ажилтан	210	192	192
620004	Гэрээт ажилтан	6	6	6
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	266	248	248
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	24	24	24
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	229	211	211
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	13	13	13

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Тайлант оны гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	317,082,360.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	317,082,360.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	308,097,320.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	308,097,320.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	308,097,320.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,985,040.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,127,700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,127,700.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	6,857,340.00

213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	6,857,340.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	317,082,360.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	317,082,360.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	27,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	290,082,360.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын Засаг даргын нь “Орон нутгийн онцлогт нийцсэн олон тулгуурт эдийн засгийг хөгжүүлж, цахимд суурилсан төрийн үйлчилгээг тэгш хүртээмжтэй хүргэнэ” эрхэм зорилгын хүрээнд сумын нийгэм эдийн засгийн чадавхыг дээшлүүлэхэд чиглэсэн оновчтой бодлого, нийгмийн салбарын хөгжлийг ахиулахад дэмжлэг үзүүлэх зорилгын хүрээнд үндсэн чиг үүргийг хэрэгжүүлж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн нэгтгэсэн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруз сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 10,496.7 сая төгрөгөөр буюу 55 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/ Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	837.4	759.8	-77.6
Авлага	1,160.5	768.8	-391.7
Урьдчилгаа	24.9	20.0	-4.9
Бараа материал	1,202.2	452.6	-749.6
Бусад эргэлтийн хөрөнгө	51.3	256.1	204.8
Үндсэн хөрөнгө	19,092.3	8,595.6	-10,496.7
Нийт хөрөнгө	22,368.6	10,852.9	-11,515.7
Өр төлбөр	3,291.1	3,109.0	-182.1
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	19,077.5	7,743.9	-11,333.6
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	22,368.6	10,852.9	-11,515.7

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл, авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн үлдэгдэл буурч, бусад эргэлтийн хөрөнгө өссөн байна. Үүнд:

- Авлагын дансны үлдэгдэл өмнөх оноос 391.7 сая төгрөгөөр буурсан нь Ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэг бүтцийн өөрчлөлтөөр улсын төсөвт шилжүүлсэн, мөн хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн авлагын үлдэгдэл 212.6 сая төгрөгөөр буурсан нь нөлөөлсөн байна.
- Бараа материалын дансны үлдэгдэл буурахад Ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэг бүтцийн өөрчлөлтөөр улсын төсөвт шилжүүлж дээд шатны төсөв захирагчид нэгтгүүлсэн нь нөлөөлсөн байна.
- Бусад эргэлтийн хөрөнгө 204.8 сая төгрөгөөр өссөн нь орон нутгийн хөгжлийн сангаар хийдсэн ашиглагч байгууллагад шилжээгүй хөрөнгө бүртгэсэн нь нөлөөлсөн байна.
- Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл буурахад Ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэгийн үндсэн хөрөнгийг бүтцийн өөрчлөлтөөр улсын төсөвт шилжүүлж, дээд шатны төсөв захирагчид нэгтгүүлсэн нь нөлөөлсөн байна.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 759.8 сая төгрөг болж, өмнөх оноос 77.5 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/ Өсөлт (+), Бууралт (-)
Касст байгаа бэлэн мөнгө	0.0	0.0	0.0
Банканд байгаа бэлэн мөнгө	0.03	33.7	-33.7
Төрийн сангийн харилцах	837.3	726.1	111.2
Дүн	837.3	759.8	77.5

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 759.5 сая төгрөгийн 726.1 сая төгрөг нь төрийн сангийн харилцах дансанд, 33.7 сая төгрөг нь ОНӨААТҮГ-ын дансны үлдэгдэл байршиж байна.

Мөнгөн хөрөнгийн харилцах дансны үлдэгдлийн 459.6 сая төгрөг буюу 63.3 хувийг хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт, хүүгийн орлого, 253.6 сая төгрөг буюу 35 хувийг ОНХС-ийн төсөл арга хэмжээний санхүүжилт, 12.9 сая төгрөг буюу 1.7 хувь төрийн сангийн харилцахын оны эхний зарцуулагдаагүй үлдэгдэл тус тус эзэлж байна.

Аудитын илрүүлэлт

Мөнгөн хөрөнгөтэй холбоотой Баруун-Урт сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгддэг харьяа байгууллагуудад нийт 373.4 сая төгрөгийн 11 алдаа, зөрчил илэрч 7.4 сая төгрөгийн зөрчилд 4 төлбөрийн акт тогтоож, 7.4 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 358.6 сая төгрөгийн 5 зөвлөмж өглөө. Үүнд:

- Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт байхгүйгээр ажил гүйлгээ хийсэн /Баруун-Урт сумын Засаг даргын тамгын газар, Баруун-Урт сумын Орон нутгийн хөгжлийн сан 358.6 сая төгрөг/
- ИТХ-ын даргын зөвлөх ажиллуулж цалинжуулсан, 80 жилийн ойн арга хэмжээнд ирсэн төлөөлөгч нарт бэлэг дурсгалын зүйл худалдан авсан /Баруун-Урт сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал 3.4 сая төгрөг/
- Цалин хөлс, нэмэгдэл урамшуулал илүү олгосон /Уртын гэгээ ОНӨААТҮГ 11.4 сая төгрөг/
- Магадлалаар баталгаажаагүй зураг төсөлтэй 6 төсөл, арга хэмжээг ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөж худалдан авах ажиллагааг зохион байгуулсан /Баруун-Урт сумын Орон нутгийн хөгжлийн сан/

3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 768.8 сая төгрөг болж, өмнөх оноос 391.8 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/сая төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	23.0	0.0	-23.0
Зээлийн хүүгийн авлага	21.4	14.8	-6.6
Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	24.9	24.9	0.0
Байгууллагаас авах авлага	21.5	8.5	-13.0
Хувь хүмүүсээс авах авлага	1,069.8	720.6	-349.2
Дүн	1,160.6	768.8	-391.8

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын дансны үлдэгдэл өмнөх оноос 391.7 сая төгрөгөөр буурсан нь Ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэг бүтцийн өөрчлөлтөөр улсын төсөвт шилжүүлсэн, мөн хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн авлагын үлдэгдэл 212.6 сая төгрөгөөр буурсан нь нөлөөлсөн байна.

Аудитын илрүүлэлт:

Авлагатай холбоотой Баруун-Урт сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгддэг харьяа байгууллагуудад нийт 25.0 сая төгрөгийн 3 алдаа, зөрчил илэрч 25.0 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, алдаа зөрчлийн давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө. Үүнд:

- Сум хөгжүүлэх сангийн хөрөнгөнөөс 2015-2019 оны хооронд зээлд хамрагдсан иргэд, аж ахуйн нэгж байгууллагын гэрээний хугацаа дуусаж, зээлийн үлдэгдэл барагдуулах асуудлыг шүүхэд шилжүүлж, шийдвэрлүүлсэн боловч иргэд үүргийн биелэлтийг хангаагүй байна. /Баруун-Урт сумын хоршоо хөгжүүлэх сан/

- Харилцагч, бэлтгэн нийдүүлэгч байгууллагатай тооцоо нийлсэн акт үйлдээгүй авлагыг тайланд тусгасан Баруунурт цэцэрлэгжүүлэлт ойн анги ОНӨААТҮГ, Уртын гэгээ ОНӨААТҮГ/

3.4.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эцсийн үлдэгдэл 24.9 сая төгрөг болж, өмнөх оноос 4.9 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 4. Урьдчилгаа дансны үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/сая төгрөгөөр/ Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Бараа материал бэлтгэх урьдчилгаа	24.9	20.0	-4.9
Дүн	24.9	20.0	(4.9)

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.4.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 708.6 сая төгрөг болж, өмнөх оноос 749.7 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/сая төгрөгөөр/ Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Эм боох материал	10.1	-	-10.1
Түрээсийн сурах бичиг	61.8	-	-61.8
Дуусаагүй үйлдвэрлэл	207.4	202.5	-4.9
Бичиг хэргийн материал	15.8	1.6	-14.2
Аж ахуйн материал	54.3	7.6	-46.7
Сэлбэг хэрэгсэл	0.7	8.6	7.9
Барилгын засварын материал	6.6	-	-6.6
Хүнсний материал	11.4	-	-11.4
Бусад хангамжийн материал	819.5	202.2	-617.3
Мал амьтад	14.6	30.0	15.4
Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/	51.3	256.1	204.8
Дүн	1,253.5	708.6	-749.7

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын дансны үлдэгдэл буурахад Ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэг бүтцийн өөрчлөлтөөр улсын төсөвт шилжүүлж дээд шатны төсөв захирагчид нэгтгүүлсэн нь нөлөөлсөн байна.

Аудитын илрүүлэлт:

Бараа материалын тайланг гаргахдаа анхан шатны баримтыг урьдчилан дугаарлаагүй, баримт засвартай, баримтыг иж бүрэн бөглөөгүй байна. /Баруунурт цэцэрлэгжүүлэлт ойн анги ОНӨААТҮГ/

3.4.5 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 11,941.1 сая төгрөг болж, өмнөх оноос 12,922.7 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/сая төгрөгөөр/ Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
----------	----------------	------------------------------------	------------------------

Барилга байгууламж	16,448.6	4,749.2	-11,699.4
Авто тээврийн хэрэгсэл	470.4	570.6	100.2
Машин тоног төхөөрөмж	1,605.6	419.0	-1,186.6
Тавилга эд хогшил	1,430.1	147.6	-1,282.5
Зам, гүүрийн байгууламж	174.8	161.8	-13.0
Номын фонд	240.5	-	-240.5
Бусад үндсэн хөрөнгө	3,193.3	3,191.8	-1.5
Программ хангамж	11.3	6.1	-5.2
Бусад биет бус хөрөнгө	1,289.2	2,695.0	1,405.8
Дүн	24,863.8	11,941.1	-12,922.7

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 72.5 сая, үнэ төлбөргүй хүлээн авсан 1,024.6 сая, шилжүүлэн авсан 2,317.8 сая, нийт 3,414.9 сая төгрөгөөр нэмэгдэж, Ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэгийн үндсэн хөрөнгийг бүтцийн өөрчлөлтөөр улсын төсөвт шилжүүлж, дээд шатын төсөв захирагчид шилжүүлсэн 15,900.4 сая, мөн шилжүүлсэн 312.5 сая, акталж данснаас хассан 124.6 сая, нийт 16,337.5 сая төгрөгөөр буурсан байна.

3.4.6 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 3,109.0 сая төгрөг болж, өмнөх оноос 182.1 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/ Өссөн+ Буурсан -
Богино хугацаат өр төлбөр дүн	74.3	14.3	-60.0
Ажилчидтай холбогдсон өглөг	4.2	0.5	-3.7
Бараа үйлчилгээний зардлын өглөг	0.0	0.0	0.0
Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг	0.0	0.0	0.0
Байгууллага төлөх өглөг	60.0	10.6	-49.4
Хувь хүмүүст төлөх өглөг	10.1	3.2	-6.9
Бусад урьдчилж орсон орлого	3,216.8	3,094.7	-122.1
Нийт дүн	3,291.1	3,109.0	-182.1

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөрийн үлдэгдэл 3,109.0 сая төгрөг болж 182.1 сая төгрөгөөр буурсан нь Ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэгийн хөрөнгийг бүтцийн өөрчлөлтөөр улсын төсөвт шилжүүлж, дээд шатын төсөв захирагчид шилжүүлсэн нь нөлөөсөн байна.

3.4.7 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 7,743.9 сая төгрөг болж, өмнөх оноос 11,321.0 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/ Өсөлт/+, бууралт /-/
Засгийн газрын оруулсан капитал	6,680.7	1,258.2	-5,422.5
/Засгийн газрын сан/ орон нутгийн сан			

Хуримтлагдсан үр дүн	9,410.1	6,446.1	-2,964.0
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,974.1	39.6	-2,934.5
Дүн	19,064.9	7,743.9	-11,321.0

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Цэвэр хөрөнгийн дүн 7,743.9 сая төгрөг болж 11,321.0 сая төгрөгөөр буурсан нь тайлант онд Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэг бүтцийн өөрчлөлтөөр улсын төсөвт шилжүүлж, дээд шатны төсөв захирагчид нэгтгүүлснээс засгийн газрын оруулсан капитал 5,422.5 сая, хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү 2,934.5 сая, хуримтлагдсан үр дүн 5,424.9 сая нийт 13,781.9 сая төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын залруулга хийж тайлант үед 11,343.2 сая төгрөгийн үр дүнгүй ажилласан нь нөлөөлсөн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 14/06 дугаар тогтоолд зааснаар сумын төсвийн татварын орлого 6,436.9 сая төгрөг, татварын бус орлого 332.0 сая нийт 6,768.9 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр татварын орлого 6,231.3 сая, татварын бус орлого 343.0 сая нийт 6,574.3 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, орлогын гүйцэтгэл 3 хувиар тасарсан байна.

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
НИЙТ ОРЛОГО	6,768.9	6,574.3
ТАТВАРЫН ОРЛОГО	6,436.9	6,231.3
Хувь хүний орлогын албан татвар	5,280.0	5,461.8
ЦХХТАОСАТ	4,300.0	4,614.9
Үйл ажиллагааны орлого	400.0	329.9
Хөрөнгө борлуулсны орлогын албан татвар	80.0	87.5
Хөрөнгийн орлого	500.0	429.5
Хөрөнгийн албан татвар	764.2	515.0
Бууны албан татвар	11.1	6.0
Үл хөдлөх хөрөнгийн татвар	603.1	409.3
Малын тоо толгойн албан татвар	150.0	99.7
Бусад татвар (төлбөр, хураамж)	239.5	208.3
Улсын тэмдэгтийн хураамж	102.9	84.9
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	136.6	123.4
Газрын төлбөр	153.2	46.2
Газрын төлбөр	153.2	46.2
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	332.0	343.0
Хүү, торгуулийн орлого	320.0	335.6
Бусад нэр заагдаагүй орлого	12.0	7.4

Орон нутгийн татварын болон татварын бус орлого төлөвлөснөөс 194.6 сая төгрөгөөр тасарсан нь үл хөдлөх хөрөнгийн албан татвар, малын тоо, толгой албан татвар, газрын төлбөрийн орлого тасарсан нь нөлөөлсөн байна.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 3,476.7 сая төгрөг, нийт зардлыг 3,476.7 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд Засаг даргын хэрэгжүүлэх 7 хөтөлбөрт зориулан 8,520.8 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 6,796.7 сая төгрөгийг урсгал төсвөөс, 300.1 сая төгрөгийг урьд оны үлдэгдлээс санхүүжих, 804.0 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас, 320.0 сая төгрөг туслах үйл ажиллагааны орлогоос, 300.0 сая төгрөгийг хоршоо хөгжүүлэх сангаас зээл, зээлийн хүүгийн орлогоос санхүүжүүлэхээр батлагджээ.

Гүйцэтгэлээр хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөөс 271.3 сая, туслах үйл ажиллагааны орлогоос 201.3 сая, орон нутгийн төсвөөс 6,596.0 сая, ОНХС-д олгох орлогын шилжүүлэг 804.0 сая, нийт 7,872.6 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 7,459.6 сая төгрөг буюу 87 хувьтай байгаа нь харилцах дансны үлдэгдлийг төсвийн нэгдсэн дансанд төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 10. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

№	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/сая төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
70105 Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага					
1	80101-Үндсэн үйл ажиллагаа	166.0	159.3	6.7	96%
2	80224- Зөвлөл, хороо, комиссын гишүүд	129.6	117.5	12.1	91%
3	80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	7.2	7.2	0.0	100%
4	81102-Орон нутгийн нөөц хөрөнгө	30.0	30.0	0.0	100%
Дүн		332.9	314.0	18.9	
70106 Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага					
1	80101-Үндсэн үйл ажиллагаа	573.9	557.6	16.3	97%
2	80103-Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ	67.4	63.9	3.5	95%
3	80106- Баг хорооны үндсэн үйл ажиллагаа	574.5	531.8	42.6	93%
4	80714-Ахмад настнуудад үзүүлэх хөнгөлөлт	17.0	16.9	0.1	100%
5	80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	45.2	45.1	0.1	100%
6	81102-Орон нутгийн нөөц хөрөнгө	100.0	98.8	1.2	99%
7	81518-Мөрийн хөтөлбөрт тусгагдсан зардал	447.4	437.9	9.5	98%
8	81549-Ахмадын сан	3.8	0.7	3.0	20%
Дүн		1,829.1	1,752.8	76.3	
71802 ерөнхий боловсрол					
1	80111-Төрийн өмчийн байгууллагын тогтмол зардал	1,270.2	1,248.7	21.5	98%
2	80112-Нийтлэг үйлчилгээ	285.1	279.4	5.7	98%
Дүн		1,555.3	1,528.1	27.25	
71401 Хог хаягдал					
1	82203-Нийтийн эзэмшлийн гудамж талбай	852.2	852.2	0.0	100.0%
2	82207-Хотын доторх ногоон байгууламж	251.2	251.2	0.0	
3	82212-Хур хог хаягдал, орчны бохирдол	791.5	778.2	13.3	98.3%
4	83401-Итгэлцүүрээр олгох	60.1	60.1	0.0	100.0%
Дүн		1,954.9	1,941.7	13.3	99.3%
70106 Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага					
1	83401-Итгэлцүүрээр	743.8	534.3	209.5	71.83%
2	83403-Ашиглалтын тусгай зөвшөөрөл	0.2	-	0.2	0.00%
3	83405-Малын тоо толгойн албан татвар	150.0	99.7	50.3	66.44%

4	83406-ОНХС-бусад	382.3	219.7	162.6	57.46%
Дүн		1,276.3	853.7	422.7	66.88%
72101 Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих					
1	82611-Жижиг дунд үйлдвэрлэл дэмжих	15.0	9.5	5.5	63.2%
2	83111-Сум хөгжүүлэх	522.8	40.0	482.8	7.7%
Дүн		537.8	49.5	488.3	9.2%
71801 сургуулийн өмнөх боловсрол					
1	80111-Төрийн өмчийн байгууллагын тогтмол зардал	765.8	751.1	14.62	98.1%
2	80112-Нийтлэг үйлчилгээ	268.8	268.8	0.05	100.0%
Дүн		1,034.6	1,019.9	14.7	98.6%
Нийт дүн		8,520.9	7,459.6	1,061.3	87.5%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 27.0 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 290.1 сая нийт 317.1 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 308.1 сая, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулалд 2.1 сая, нийт 310.2 сая төгрөгийг зарцуулж үлдэгдэл 6.9 сая төгрөгийг төрийн сангийн дансанд төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баруун-Урт сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах дотоод хяналт, цалин хөлстэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2023 оны 3 дугаар сарын 15 -аас 2023 оны 3 дугаар сарын 25 -ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2023 оны 3 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Засаг даргад хүргүүлэхээр төлөвлөн, Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

Тэргүүлэх аудитор М.Нарантуяа, аудитын менежер Г.Даваа нар үе шатны хяналтыг хэрэгжүүлж, аудитор Б.Мөнхбамбар гүйцэтгэв.

Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 1/94 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлаар сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нийт 15,600.8 сая төгрөгийн зардлын 2 хувь буюу 312.0 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшнийг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Баруун-Урт сумын Засаг даргын тухай хуульд хамаарах зүйл заалт бүрээр горим сорил хэрэгжүүлсэн. Баруун-Урт сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал аймгийн 80 жилийн ойн арга хэмжээнд ирсэн төлөөлөгч нарт бэлэн дурсгалын зүйл худалдан авсан, ИТХ-ын даргын зөвлөх ажиллуулж цалинжуулж төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан 3.4 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим системд тайлант онд гарсан өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой гаргасан тушаал шийдвэр, орлого зарлагын мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн байршуулсан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай болон бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийн талаар бичнэ.

Хүснэгт 12. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитаар		Биелэлт		/сая.төг/ Хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Зөвлөмж	3	-	3	-	100
Нийт дүн	3	-	3	-	100

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 57.8 сая төгрөгийн зөрчил¹ илэрснээс зөрчлийг дахин давтан гаргахгүй байх 57.8 сая төгрөгийн 1 зөвлөмж өглөө.

5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

5.1.1 Орлогын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Малын тоо толгойн албан татвар 57.8 сая төгрөгийн орлогыг дутуу төвлөрүүлсэн нь Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 /Албан татвар төлөгчийн өмчилж буй Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа малын тоо толгойд албан татвар ногдуулна/, 5.2 /Тухайн татварын жилд албан татвар ногдуулах малын тоо толгойг Статистикийн тухай хуульд заасны дагуу хийгдсэн өмнөх жилийн мал тооллогын дүнд үндэслэн тодорхойлно./, 6 дугаар зүйлийн 6.2 /Албан татварын хэмжээг энэ хуулийн 6.1-д заасан хязгаарт багтаан сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал малын төрөл тус бүрээр тогтооно/, 7 дугаар зүйлийн 7.1 /Албан татвар төлөгч энэ хуулийн дагуу ногдуулсан албан татварыг тэнцүү хоёр хуваан тухайн жилийн 7 дугаар сарын 15, 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор өөрийн өмчилж байгаа малын тоо толгой тоологдож бүртгэгдсэн сум, дүүргийн төсөвт төлнө/, Төсвийн тухай хуулийн 41 дугаар зүйлийн 41.2.1 /хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх/, тус тус зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:

Малын тоо толгойн албан татварыг төвлөрүүлэх чиглэлээр Багийн засаг дарга, татварын байцаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тодорхой арга хэмжээ болгон тусгаж, биелэлтийг хангуулах, мөн уг албан татвараар төвлөрсөн хөрөнгийг буцаан малчдад үйлчилгээ үзүүлэх тохиолдолд татвар төлсөн байдлыг шалгуур үзүүлэлт болгон авч үзэхийг зөвлөж байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 09 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
ЗДТГазар	2	-	-	-	1	-	1	-	-	-	-	-	-
ИТХурал	2	3.4	2	3.4	-	-	-	-	-	-	-	-	-
ОНХСан	2	358.6	-	-	2	358.6	-	-	-	-	-	-	-
ХХСан	1						1						
Баруунурт цэцэрлэгжүүлэлт ойн анги ОНӨААТҮГ	6	-					6	-					
Дүн	9	437.1	1	1.1	5	436.0	3	-	-	-	-	-	-